

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛ

_____он _____сар _____

дугаар

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5, 29 дүгээр зүйлийн 29.1.5 дах хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, олон нийтэд зориулсан мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах заавар"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга (хошууч генерал Г.Ариунбуян)-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шадар сайдын Ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх (Б.Мөнх-Оргил)-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН

БОЛЗОШГҮЙ ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгааг бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр иргэд, олон нийтэд цаг алдалгүй хүргэж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд энэхүү зааврын зорилго оршино.

1.2. Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор баталсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоол “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн хүрээ хөтөлбөрийн дунд хугацааны стратеги”-ийг удирдлага болгон энэхүү зааврыг хэрэгжүүлнэ.

1.3. Энэхүү зааврыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, төв, орон нутгийн Онцгой байдлын газар болон гамшгаас хамгаалах улсын албад дагаж мөрдөнө.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг олон нийтэд сурталчилан таниулах, түгээх ажлыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага түүний харъяа нэгжийн гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан, гамшгаас хамгаалах улсын албад хариуцан зохион байгуулна.

Гурав. Гамшиг аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээний төрөл

3.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, сурталчилгааг дараах арга, хэлбэрээр зохион байгуулна.

3.1.1. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх:

1. Хэвлэлийн бага хурал зохион байгуулж, үндэсний болон олон нийтийн радио телевиз, бусад хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан, үнэн бодит, нээлттэй мэдээлэл хүргэх.
2. Нийгмийн сүлжээ: Нийгмийн сүлжээний платформоор дамжуулан зурагт хуудас, видео хэлбэрээр түгээх.
3. Вэб сайт, блог, подкаст: Гамшгийн эрсдэл, урьдчилан сэргийлэх мэдээлэл бүхий зөвлөгөө нийтлэлүүд.

3.1.2. Хэвлэмэл материал тараах.

1.Сурталчилгааны зурагт хуудас: Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох мэдээлэл бүхий зөвлөгөө, зөвлөмжүүд.

2.Комикс, ном, товхимол, гарын авлага, санамж, танилцуулга: Хүүхдэд зориулсан сургалтын материалууд. /Аврагч мазаалайн зөвлөмж, Бэлэн бай гарын авлага, модуль, “Аюулгүй амьдрах ухаан” теле хичээл/

3.1.3. Үүрэн холбооны операторууд:

1. SMS мэдэгдэл, e-mongolia академи: Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолоор баталсан “Ус, цаг агаар орчны аюултай, гамшигт үзэгдлийн талаар урьдчилан сэргийлэх мэдээ дамжуулах журам”-ын 5 дахь хэсэгт заасны дагуу иргэдэд шуурхай анхааруулга, сэрэмжлүүлэг түгээх.

2. QR холбоос бүхий материал: Иргэд холбогдох мэдээлэл рүү хялбар нэвтрэх боломжоор хангагдана.

Дөрөв. Мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг түгээх үйл ажиллагаа:

4.1. Гамшигын өмнөх үе буюу өдөр тутмын урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээх:

4.1.1. Иргэд, олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн аян, өдөрлөгийн арга хэмжээг улирал, цаг үетэй уялдуулан тогтмол зохион байгуулна.

4.1.2. Монгол Улсын Шадар сайдын баталсан нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу энэхүү зааврын 5 дахь хэсэг “Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг түгээх цагалбар”-т нийцүүлэн урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг олон нийтэд түгээх төлөвлөгөөг улс даяар болон орон нутгийн онцлогт тохируулан боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.1.3. Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг www.nema.gov.mn, www.belenbai.mn сайт, “ОБЕГ-ын Урьдчилан сэргийлэх мэдээлэл” пейж хуудаснаас татан авч, урьдчилан сэргийлэх сургалт, өдөрлөгийн арга хэмжээнд ашиглаж, түгээнэ.

4.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед:

4.2.1. Гамшигын нөхцөл байдал, хариу арга хэмжээ болон бусад цаг үеийн мэдээллийг тогтмол шинэчилж хүргэнэ.

4.2.2. Иргэдэд мэдээллийг нэг урсгалаар тогтсон цагт хүргэх зорилгоор мэдээллийн цагийг тогтмол зохион байгуулна.

4.3 Мэдээлэл түгээх үйл явц, албан тушаалтан

4.3.1 Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх болон гамшигын нөхцөл байдлын үед мэдээлэл түгээх үйл ажиллагааг “Онцгой байдлын байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-аар зохицуулна.

**Тав. Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх
мэдээ, мэдээллийг түгээх цагалбар:**

д/д	Гамшиг, аюулт үзэгдэл, ослын төрөл	Сарууд												Хариуцах байгууллага, албан тушаалтан
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Гамшгийн өмнөх үед														
1.	Ой, хээрийн гал түймэр													ОБЕГ-ын УСОНХХ, ТОНОБГ-ын гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан
2.	Газар хөдлөлт													
3.	Объектын галын аюулгүй байдал													
4.	Мөсний цөмрөлт													
5.	Шар усны үер													
6.	Үер, усны осол													
7.	Ган, зуд													
8.	Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга													
9.	Хүн, малын гоц халдварт өвчин													
10.	Цацраг, химийн осол													
Гамшгийн үед														
1	Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед	Тухайн цаг хугацаанд												УОК-ын Шуурхай штаб, ОБЕГ, төв орон нутгийн томилгоот нэгжүүд

Зургаа.Бусад:

6.1. Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, удирдлагуудын орон нутагт ажиллаж байгаа томилолт, зохион байгуулж байгаа томоохон арга хэмжээ, сургалтын талаарх мэдээллийг meta.gov.mn сайтад байршуулсны дараа татан авч өөрийн нэгжийн пейж хуудсанд байршуулна.

6.2. Гамшгаас хамгаалах улс, орон нутгийн албад нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй гамшиг аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх нөлөөллийн аян, нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгт идэвх санаачилгатай оролцож, сурталчилах арга хэмжээ зохион байгуулна.

6.3. Төв орон нутгийн Онцгой байдлын газар, нэгжийн албан ёсны цахим хуудсанд эх сурвалж тодорхойгүй, бусад байгууллагын бэлтгэсэн эх материалын загварыг өөрчлөн хуулбарлахыг хориглоно.

6.4. Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтсээс зөвшөөрөөгүй тохиолдолд хэвлэл мэдээллийн байгууллагад урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллээс бусад аливаа мэдээ, мэдээлэл, ярилцлага өгөхийг хориглоно.

6.5. Энэхүү зааврын хэрэгжилтэд Онцгой байдлын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газрын Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтэс хяналт тавина.

---oOo---